

КОМПАНИЙН ТУХАЙ

1994 онд үүссэн байгуулагдсан Ард Даатгал компани нь 23 жил үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж өдгөө Монгол улсыг бүхэлд нь хамарсан 25 салбар, 230 гаруй төлөөлөгчтэй, 100 гаруй ажиллагсадтай даатгалын компани болон өргөжөөд байна.

Тус компани нь харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг тэргүүн зэрэгт хүндэтгэн үзэж, даатгалын зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэн, өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглон, эрх зүйн харилцааны хэм хэмжээг мөрдөн, зүй бус хэлцэлд оролцохоос татгалзаж, үйл ажиллагаандаа нээлттэй, шударга ёс зүйг баримтлан ажилладаг.

Аливаа даатгалын компанийн хувьд даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадамжийг илэрхийлдэг гол үзүүлэлт нь төлбөрийн чадварын үзүүлэлт юм. Ард Даатгал компанийн хувьд уг үзүүлэлт нь СЗХ-ны 2016 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан "Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам"-ын тооцооллоор зохих түвшинд байна.

ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР, ДАВХАР ДААТГАЛ (САЯ ТӨГ)

	2013	2014	2015	2016
Хураамж	10,094	10,106	9,160	7,172
Нөхөн төлбөр	2,557	3,095	3,829	2,596
Давхар даатгал	4,234	1,816	1,842	1,346

ЗАРДЛЫН ХАРЬЦАА БОЛОН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

	2013	2014	2015	2016
Зардлын харьцаа	0.54	0.57	0.59	0.65
Хохирлын харьцаа	0.41	0.41	0.59	0.44

НИЙТ ХӨРӨНГӨ, НӨӨЦ САН (САЯ ТӨГРӨГ)

	2013	2014	2015	2016
Нийт хөрөнгө	7,128	8,649	8,759	9,541
Нөөц сан	3,240	4,163	4,532	4,355

ДААТГАЛЫН БАГЦЫН МЭДЭЭЛЭЛ

	2015 он				2016 он			
	Хураамж		Нөхөн төлбөр		Хураамж		Нөхөн төлбөр	
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	440.86	4%	335.20	9%	460.62	6.4%	126.17	4.9%
Хөрөнгийн даатгал	2,924.85	31.9%	266.96	7%	1,280.79	17.9%	200.50	7.7%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,229.98	13.4%	823.40	22%	921.40	12.8%	755.88	29.1%
Ачааны даатгал	299.13	3.3%	108.13	3%	282.78	3.9%	18.58	0.7%
Барилга угсралтын даатгал	208.69	2.3%	6.21	0%	294.95	4.1%	9.11	0.4%
Мал амьтдын даатгал	-	0.0%	-	0%	39.22	0.5%	-	0.0%
Агаарын хөлгийн даатгал	1,127.99	12.3%	-	0%	1,180.21	16.4%	67.46	2.6%
Жолоочийн хариуцлагын даатгал	2,294.18	25.0%	1,712.14	45%	1,761.81	24.6%	1,028.94	39.6%
Хариуцлагын даатгал	612.39	6.7%	48.02	1%	920.15	12.8%	44.82	1.7%
Санхүүгийн даатгал	21.56	0.2%	528.20	-	30.11	0.4%	344.30	13.3%
Нийт	9,159.63	100.0%	3,828.56	100.0%	7,172.29	100.0%	2,596.76	100.0%

#1

2012 & 2013
оны шилдэг
даатгагч

108

нийт
ажилчдын
тоо

23

Үйл
ажиллагаа
явуулсан
жил

#2

2015 онд ТХД-н
хохирол
төлөлтийн
харьцаа
үзүүлэлт

25

Салбар
төлөөлөгчийн
газар

232

Төлөөлөгчийн
тоо

#3

2016 онд ЖД-н
хохирол
төлөлтийн
харьцаа
үзүүлэлт

7%

Зах зээлд
эзлэх хувь

54K

Даатгуулагчийн
тоо

ДАВХАР ДААТГАЛ

Бид давхар даатгалын үйл ажиллагааг СЗХ-ны дүрэм журам, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олон улсад мөрдөгддөг хэм хэмжээний дагуу явуулдаг бөгөөд өнгөрсөн 20 гаруй жилд ихээхэн туршлага хуримтлуулж, олон улсын давхар даатгалын зах зээлд нэр хүндтэй дотоодын даатгагч болж чадсан.

• Бид Hannover Re, MSH International компаниудтай хамтран олон улсын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг гаргаж харилцагчиддаа санал болгож байна.

• Мөн Азийн орнуудын давхар даатгалын зах зээлд гарах зорилготойгоор Японы Marnix олон улсын давхар даатгалын брокерын Монгол дахь албан ёсны түншээр хамтран ажиллаж байна.

• ХБНГУ-д төвтэй Европын холбооны даатгалын групп Allianz нь Ард Даатгалыг Монгол дахь албан ёсны стратегийн түншээр сонгон ажиллаж байна.


• Бид Монгол улсын зах зээлд эрсдэлийн менежментийг нэвтрүүлж, трити гэрээгээр эрсдэл даах чадамжаа жилээс жилд өсгөж, түргэн шуурхай үйлчилгээгээр хангаж ирсэн билээ. Трити гэрээний давхар даатгагч нь дэлхийн тэргүүлэх давхар даатгалын Hannover Re компани юм. Уг гэрээ нь манай эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхээс гадна харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт олгодог.

• Бид ОХУ-ын Ингосстрах, Францын Europ Assistance компанитай хамтран гадаад аялагчдын даатгалын үйлчилгээг санал болгож байна.

Шууд даатгагчийн хувьд бид:

- Эд хөрөнгө
- Барилга угсралт
- Агаарын хөлгийн иж бүрэн даатгал
- Байгууллагын хариуцлагын даатгал
- Мэргэжлийн хариуцлагын даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Олон улсын эрүүл мэндийн даатгал зэргийг давхар даатгалын брокеруудаар дамжуулан гүйцэтгэж, олон улсын стандартын дагуу, үйл ажиллагааны онцлог тус бүрт тохирсон хамгийн найдвартай даатгалын хамгаалалт, эрсдэлийн удирдлагын үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж байна.

МАНАЙ ГЭРЭЭНД ТҮГЭЭМЭЛ ОРОЛЦОЖ БҮЙ ДАВХАР ДААТГАГЧ НАР



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Ард Даатгал компани нь ердийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сайн дурын болон албан журмын төрөл бүхий 50 гаруй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байна.



ТҮҮХЭН ЗАМНАЛ

- 2016** Олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв
- 2015** Даатгалын цахим мэдээллийн сантай болов.
- 2014** Ард Санхүүгийн Нэгдэл ХХК хөрөнгө оруулагч болов.
- 2013** Монгол улсын Татварын Ерөнхий Газрын дээд шагнал “Хөх дэвтэр” гардав.
- 2012** МХАУТ -ын шалгаруулалтаар “Оны шилдэг даатгалын компани” болов.
- 2011** Grand Expo -ийн “Оны шилдэг даатгалын компани” болов.
- 2010** Гранд Даатгал ХХК -ийг өөртөө нэгтгэв.
- 2008** “International Quality Era Award” (Switzerland, Geneva) шагнал гардав.
- 2004** СЗХ-ны “Оны шилдэг даатгалын компани” болов.
- 2000** Их Британийн “Omni Whittington Group” хөрөнгө оруулагч болов.
- 1994** Монгол улсын “ТОП-5” даатгалын компанийн нэг болов. Ард Даатгал ХХК үүсгэн байгуулагдав.

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД



БРОКЕРУУД

